



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН  
ТУШААЛ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/11

Дэлгэрхаан сум

**Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн  
зааварчилгаа батлах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 заалт, 28 дугаар зүйлийн 28.1.6 үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага, ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн хэмжээд мөрдөх зарим ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгааг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан зааварчилгааг мөрдүүлэн ажиллахыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтанд даалгасугай.

3. Ажлын байрны батлагдсан зааврыг мөрдөж ажиллахыг нийт ажилчдад үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ



О.БАТБАЯР

Эрхлэгчийн 2025 оны 05 сарын 05 өдрийн

4111 тоот тушаалын 1 хавсралт

## БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЖУРАМ

### Нэг. Журмын зорилго

Эрүүл мэндийн төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Ерөнхий зүйл

1. Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй нь ажил үүргээ гүйцэтгэх явцад болон түүнтэй холбоотой үүсэх осол, эрүүл мэндийг гэмтэхээс урьдчилан сэргийлэх, ажлын байрын орчноос бий болсон аюулын шалтгааныг арилгах зорилгоор Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах хэрэгслээр хангах Хөдөлмөрийн хууль бусад холбогдох баримт бичгийг судлан хэрэгжилтийг ханган ажиллах цогц арга хэмжээ юм.

2. Байгууллагын хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг зохион байгуулахдаа Монгол улсын хууль, Засгийн газар бусад эрх бүхий байгууллага, тэдгээрээс гаргасан шийдвэр, эрх зүйн баримт бийг болон дүрэм, журмыг удирдлага болгоно.

### Гурав. Нийтлэг шаардлага

1. Байгууллагын нийт албан хаагчид ажил эхлэхээс өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын давтан зааварчилгааг амаар болон бичгээр авч гарын үсэг зурж баталгаажуулсны дараа ажил үүрэгтээ орно.

2. Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн бусад албан хаагчид ажлын байранд ажлын хувцсыг бүрэн өмссөн байх, мэс ажилбар хийх үед зориулалтын өмд, цамц, углааш, малгай, амны хаалт, нүүрний хаалт, нүд хамгаалах хэрэгсэл болох нүдний шилийг хагалгааны хэсгийн сувилагчийн шаардлагыг биелүүлж, халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллана.

3. Тоног төхөөрөмжүүдийн ажиллагаа хэвийн, аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.